



ДУНДГОВЬ АЙМАГ  
ДЭЛГЭРХАНГАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/45

Хашаат

Эрчим хүчний хамгаалалтын зурвас  
тогтоох тухай

Монгол Улсын Эрчим хүчний тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2, Засгийн газрын 2001 оны 263 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын нутаг дэвсгэрт эрчим хүчний шугам сүлжээний аюулгүй ажиллагааг хангах, хүн амьтан осолдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор ЦТСС-ын эзэмшилд буй дэд станцын хамгаалалтын зурвас, ЦДАШ-ын хамгаалалтын зурвасыг хавсралтаар баталсугай.

2. Хамгаалалтын зурвасын хэмжээг тогтоосон тухай шийдвэрийг олон нийтэд сурталчилан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цахилгаан түгээх сүлжээний шуурхай үйлчилгээний засварын монтер, хамгаалалтын зурвасын хэмжээг мөрдөж ажиллахыг нийт аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.ОДБАЯР



Сумын Засаг даргын  
 2023 оны 01 дугаар сарын 22 ний өдрийн  
 ...45... дугаар захирамжийн хавсралт



ЦТСС, ЦДАШ-ын эзэмшилд буй дэд станцын  
 хамгаалалтын зурвасын хэмжээ

№	Дэд станцын нэр	Ашиглалтанд орсон	Дэд станцын хашааны хэмжээ			Хамгаалалтын зурвасын хэмжээ		
			Өргөн /м/	Урт /м/	Талбай /м/	Өргөн /м/	Урт /м/	Талбай /м <sup>2</sup> /
1	2	3	4	5	6	7	8	9
1	15/0,4 кВ АТП-45	2002	4.7	5.4	25.4	14.7	15.4	226.38
2	15/0,4 кВ АТП-116	2017	4.7	5.4	25.4	14.7	15.4	226.38

№	Шугамын нэр	Ашиглалтанд орсон	Дэд станцын хашааны хэмжээ			Хамгаалалтын зурвасын хэмжээ		
			Хүчдэл	Хэлхээ	Шугамын урт /км/	Өргөн /м/	Урт /м/	Талбай /м <sup>2</sup> /
1	2	3	4	5	6	7	8	9
15 кВ хүчдлийн ЦДАШ:								
1	15 кВ ЦДАШ	2002	15 кВ	1	58,8	10	58750.0	587500.0
0,4 кВ хүчдлийн ЦДАШ:								
2	0.22-0.4 кВ ЦДАШ	2002	0.4 кВ	1	9.1	2	9050.0	18100.0